



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Г Өмч хамгаалах байнгын зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоол, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд: Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн Нийгмийн үйлчилгээний стандарт хариуцсан мэргэжилтэн

Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн Ногоон байгууламжийн стандарт хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчны стандартын хэлтсийн Бүртгэл, мэдээллийн сангийн мэргэжилтэн

Агентлаг хариуцсан нярав

Нарийн бичгийн дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн Архивын ажилтан

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл (Э.Даваахатан)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА   
С.ТӨМӨРДУЛАМ

1150500224